

Өрхийн Эмнэлгийн үүсэл хөгжилт

Эрүүл мэндийн ахан шатны тусламжид суурилсан нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амд ойртуулах зорилгоор ЭМСХХ-1-ийн хүрээнд МУ-ын ЗГ-ы 1999 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Өрхийн эмнэлгийг зохион байгуулан ажиллуулах тухай” 149,193-р тогтоол, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх” тухай 2000 оны 72 дугаар тогтоолууд тус тус гарч, Улаанбаатар хотод 1999 онд 2 дүүрэгт туршилтын журмаар 40 өрхийн эмнэлэг зохион байгуулж эхэлсэн.бөгөөд 2000 оноос Өрхийн эмнэлгийн ББН-ийн хэлбэрээр бие даалган ажиллуулах нь зүйтэй гэж үзсэний дагуу Өрхийн эмнэлгийн тогтолцоонд шилжих шилжилтэд эргэлт буцалтгүй орсон.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан ЭМСХХ-ийн салбар нэгж Улаанбаатар хотод өрхийн эмнэлгийн зохион байгуулах, дэмжин хөгжүүлэх ажлыг гардан гүйцэтгэсэн. 2000-2002 он гэхэд Улаанбаатар хотод Эрүүл мэндийн анхан шатны тусламжид суурилсан урьдчилан сэргийлэх болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх 119 өрхийн эмнэлэг байгуулагдсан үйл ажиллагаандаа орсон нь нийслэлийн эрүүл мэндийн салбарын хувьд томоохон шинэчлэл болсон.

Энэхүү ажлын хүрээнд Эрүүл мэндийн нэгдэл дээрээ төвлөрөн байрлаж байсан өрхийн эмнэлгүүдийг хүн амд нь ойртуулан байршуулж, өрхийн эмнэлэг болон өрхийн эмч бүрийг эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмж, иж бүрэн компьютер ийн хэрэгслээр ханган, бүх өрхийн эмч, сувилагч нарыг менежментийн болон мэргэжил дээшлүүлэх эмнэлт зүйн давтан сургалт-анд хамруулан лицензжүүлж, мэргэжлийн гарын авлагаар хангасан төдийгүй улмаар өрхийн эмнэлгүүд 100% магадлан итгэмжлэгдсэн нь иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чанартай хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Одоо нийслэлд 124 өрхийн эмнэлэг дүүргийн Засаг дарга, Эрүүл мэндийн нэгдлийн дарга нартай гурвал сан гэрээ байгуулан ажиллаж, нийслэлийн 1,0006,184 хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эдгээр өрхийн эмнэлгүүдэд нийт 1226 буюу 498 эмч, 438 сувилагч, 290 үйлчлэгч, туслах ажилтан ажиллаж, 1 эмчид дунджаар 2020 буюу албан бусаар 2500-3100 хүн ам ногдож байгаа бөгөөд судалгаагаар нийт хүн амын 83,1% өрхийн эмнэлгээр үйлчлүүлж байна. Ийнхүү өрхийн эмнэлгийг хувийн хэвшлийн хэлбэрээр зохион байгуулж, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх болсон нь зах зээлийн өнөөгийн нийгэмд эрүүл мэндийн салбараас хийсэн томоохон шинэчлэл болсон, төр засгаас шинэчлэлт өөрчлөлтийг бодлогын хүрээнд зөв зохистой хөгжүүлэх шаардлага нэн тулгамдсан асуудал юм. Өрхийн эмнэлгийн олсон ололт, туршлагад дээр суурилан, боловсронгуй болгож хөгжүүлэх нэн тэргүүнд тавигдаж байна.

2002 оны ЭМГ-ын даргын 51дүгээр тушаалаар "Нийслэлийн Загвар өрхийн эмнэлэг" шалгаруулах болзлыг анх туршсан

2005 оны ЭМГ-ын даргын 46 дугаар тушаалаар "Нийслэлийн Загвар Өрхийн эмнэлэг" шалгаруулах журам, болзлыг шинэчлэн боловсруулж, зэрэглэлтэй болгосон.

Болзол нь: 5 бүлэг 50 зүйлтэй

Удирдлага, зохион байгуулалт

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

Ариун цэвэр, халдвар хамгаалал, тохижилт үйлчилгээ
Сургалт сурталчилгаа

Бусад үйл ажиллагаа

Ач холбогдол хүрэх үр дүн:

1. Удирдлага, зохион байгуулалт, тохижилт, тусламж үйлчилгээ, үйл ажиллагаагаараа тэргүүний өрхийн эмнэлгүүд бий болж, бусдад "Загвар" болно.

2. Загвар өрхийн эмнэлэг олшрох тусам үйлчлүүлэгсдэд таатай, ээлтэй орчин бүрдсэн, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай үзүүлдэг өрхийн эмнэлгүүд олноор бий болно.

3. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ чанартай, хүртээмжтэй хүрнэ.

4. Иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.

НЗД-ын 2003 оны 576 дугаар захирамж, НЭМГ, Улаанбаатар телевизийн захирлын хамтарсан 122/70 ЭМГ-ын даргын 57 дугаар тушаалуудын дагуу "Эрүүл мэндээ дээдлэгч иргэн, өрх, байгууллагыг шалгаруулах ажлыг 2003 оноос эхлэн жил бүр зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн нэгдэл нэгдсэн эмнэлгүүдэд өөрийн эмнэлгийн онцлогт тохируулан өрхийн эмнэлгүүдэд ор хуваарилан, хяналт таьж ажиллах тухай Эрүүл мэндийн газрын даргын 2007 оны 57 дугаар тушаалыг гарган мөрдөж ажилласан.

2001 онд Нийслэлийн өрхийн эмч нарын анхдугаар чуулган "Эрүүл мэндийн суурь тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг шинэ шатанд гаргая

2002 онд Монголын өрхийн эмч нарын анхдугаар чуулган

2007 онд Монголын өрхийн эмч нарын 2 дугаар чуулган "Өрхийн эмнэлгийн хөгжлийн асуудалд"

2008 Нийслэл өрхийн сувилагч нарын анхдугаар зөвлөгөөн "Өрхийн эмнэлгийн хөгжлийн төлөө хамтдаа" уриан дор тус тус зохион байгуулагдсан.

Энэхүү чуулгануудаараа өрхийн эмнэлгийн үйл ажиллагаанд дүгнэлт хийн, олсон ололт, амжилт, дутагдалдаа хэлэлцэж, тухай бүр тулгамдсан асуудлуудаа дэвшүүлэн тавьж, зөвлөгөөнд оролцогсдоос зөвлөмжийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжүүлэн ажиллаж иржээ.

Дүгнэлт:

Иргэдэд Эрүүл мэндийн анхны тусламж үйлчилгээ ойртсон

Өрхийн эмнэлгүүдийн ажиллах таатай орчин бүрдсэн

Өрхийн эмнэлгүүдийн багаж тоног төхөөрөмжийн хангамж зохих хэмжээнд нэмэгдэж, тусламж үйлчилгээний цар хүрээ өргөжиж байна.

Өрхийн эмнэлгийн үйл ажиллагаа тогтворжсон